

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ТЗУХ-ИЙН ТҮНТ-ИЙН  
2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 7-13-НЫ  
ӨДРҮҮДЭД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭ

2023 оны 04 дүгээр сарын 13

Хэрлэн сум

Өргөдөл гомдол санал хүсэлтийн мэдээлэл: Иргэдээс 705631111 утсанд 16 иргэн санал хүсэлт, өргөдөл гомдол ирүүлсэн. Шууд хариу өгөх боломжтой, хариу өгсөн 14, шийдвэрлэлтийн шатандаа 2 байна.

Утгаар нь авч үзвэл: Аймаг дотор явдаг такси үйлчилгээний үнэ өндөр байна, Автобус иргэдэд талон өгдөггүй, жолооч нар нь өөрсдөө бэлэн мөнгөө авдаг нь зөв үү, үйлчилгээний стандарт ямар байх ёстой вэ? Сангийн аж ахуйн Т-163, 164, 165-р байрнууд нойл байдаггүй учир 167-р байрны орчим маш их хог, ахуйн бохирдолтой байна, нойлын асуудлыг шийдвэрлүүлж өгнө үү гэсэн хүсэлтүүд ирүүлж шийдвэрлэлтийн шатандаа байна.

Шийдвэрлэлтийн шатандаа хариу өгөгдөөгүй өргөдөл Нийгмийн бодлогын хэлтэст-2, Хууль эрх зүйн хэлтэст-2, Хэрлэн сумын ЗДТГазарт -2,

705631111 утсанд хотоос хөдөө орон нутагт шилжин ирэх тухай санал хүсэлт 4 иргэн хандсан нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхэд газартай холбоот 2, малжуулах төсөл хөтөлбөрт хамрагдах тухай 2, холбогдох мэдээллийг өгсөн.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд нийт 507 иргэн үйлчлүүлснээс. өөртөө үйлчлэх танхимаар 199, утсаар 32, цахим 26, биечлэн 250 иргэн үйлчлүүлснээс. Улсын бүртгэлээр 102, Хөдөлмөр халамжийн үйлчилгээгээр 30, Хууль зүйн зөвлөгөөгөөр 9 иргэнд зөвлөгөө өгсөн. Нотариатын үйлчилгээгээр 29, e-mongolia сурталчилах цэгээр 11, E-khutuch.mn булангаар 4, Төрийн банк 38, Өндөрхаан инвест БДК-аар 10, Жи-мобайлаар 17 иргэн үйлчлүүлсэн.

Үнэлгээний төхөөрөмжинд нийт 250 үнэлгээ өгөгдсөнөөс: Маш сайн 229, сайн 11, дунд 5, муу 5, үнэлгээ өгөгдсөн байна.

Өргөдөл гомдлын 2023 оны 1-р улирлын тайланг ЗГХЭГазарт хүргүүлсэн.